

ГАРЧИГ

ОРШИЛ.....	2
I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
III ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	10
V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	13
V.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
V.4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө	14
V.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	14
V.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
V.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
V.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
V.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	16
V.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	17
V.11 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	18
V.12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	19
ДҮГНЭЛТ	20
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ.....	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	3
Хүснэгт 2.	Уурхайн солбилцол.....	3
Хүснэгт 3.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт 4.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 5.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	16
Хүснэгт 7.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	16
Хүснэгт 8.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	17
Хүснэгт 9.	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	18
Хүснэгт 10.	Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал.....	19

ОРШИЛ

“Эм Эс бэл майнинг” ХХК-ийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ–нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

“Эм Эс бэл майнинг” ХХК-ийн Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ашиглах төсөл нь өмнөх жилүүдэд бүрэн хүчин чадлаар ажиллаж чадаагүй, ордын нөөцийг бүрэн ашиглаж дуусаагүй байгаа тул 2026 онд уурхайн хаалт хийгдэхгүй. Иймд төслийн БОННУ-ний тайлангийн хаалтын өмнөх жилийн менежментийн төлөвлөгөөг урьтал болгон 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 17,152,000 төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөвлөгөөний нэр: Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших 40.64 га талбайг хамарсан Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Эм Эс бэл майнинг” ХХК

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Эм Эс бэл майнинг” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011839169
3	Уурхайн нэр		Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон орд
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Өвөрхангай
5		Сум/Дүүрэг	Зүүнбаян-Улаан
6	Ашигт малтмалын төрөл		Алтны үүсмэл болон шороон
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-000436
8	Ашиглалт эхэлсэн огноо		
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Хан-Уул
11		Баг/Хороо	4-р хороо
12		Гудамж/Байр	Арцатын ам, 1460, 87 тоот
13		Гар утас	+976-86045566
14	Захирлын хаяг	Нэр	Б. Тогооч
15		Гар утас	+976-89298252
16		Цахим шуудан	toogiit827@gmail.com


Төслийн байршил: “Өртөнтийн урд дэнжийн хэсэг”-ийн алтны үүсмэл болон шороон орд нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт 449 км, Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумаас баруун хойш 22 км зайтай байрлана.

- Засаг захиргаа: Өвөрхангай аймаг, Зүүнбаян-Улаан сум
- Ордын нэр: "Өртөнтийн урд дэнжийн хэсэг"
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Алтны үүсмэл болон шороон орд
- Трапедийн номенклатур: L-48-49
- Талбайн нийт хэмжээ: 40.64 га

Хүснэгт 2. Уурхайн солбицол

№	Газарзүйн солбицол					
	Өргөрөг			Уртраг		
1	46	37	39.36	102	23	15.23
2	46	37	39.44	102	23	18.88
3	46	37	52.23	102	23	18.28
4	46	37	52.39	102	23	25.56
5	46	37	58.86	102	23	25.24
6	46	37	58.87	102	23	26.17
7	46	37	14.92	102	23	25.4
8	46	37	14.03	102	23	23.9
9	46	37	6.93	102	23	21.09
10	46	37	5.24	102	23	21.17
11	46	37	5.23	102	23	20.42
12	46	37	59.51	102	23	18.16
13	46	37	58.7	102	23	18.2
14	46	37	58.68	102	23	17.83
15	46	37	22.43	102	23	3.48
16	46	37	16.85	102	23	3.76

№	Газарзүйн солбицол					
	Өргөрөг			Уртраг		
17	46	37	16.81	102	23	3.97
18	46	37	16.76	102	23	4.21
19	46	37	16.74	102	23	4.33
20	46	37	16.6	102	23	4.91
21	46	37	16.56	102	23	5.08
22	46	37	16.5	102	23	5.28
23	46	37	16.38	102	23	5.68
24	46	37	16.2	102	23	6.23
25	46	37	16.17	102	23	6.3
26	46	37	16.1	102	23	6.48
27	46	37	15.92	102	23	6.94
28	46	37	15.68	102	23	7.45
29	46	37	15.62	102	23	7.59
30	46	37	15.54	102	23	7.74
31	46	37	15.35	102	23	8.1
32	46	37	15.07	102	23	8.56
33	46	37	14.92	102	23	8.78
34	46	37	14.85	102	23	8.87
35	46	37	14.7	102	23	9.09
36	46	37	14.38	102	23	9.5
37	46	37	14.24	102	23	9.66
38	46	37	14.16	102	23	9.75
39	46	37	13.97	102	23	9.96
40	46	37	13.61	102	23	10.31
41	46	37	13.58	102	23	10.33
42	46	37	13.48	102	23	10.42
43	46	37	13.19	102	23	10.67
44	46	37	13.68	102	23	32.12
45	46	37	20.15	102	23	31.8
46	46	37	20.04	102	23	27.11
47	46	37	23.28	102	23	26.96
48	46	37	23.2	102	23	23.43
49	46	37	26.45	102	23	23.03
50	46	37	26.42	102	23	16.08



Орд ашиглах тусгай зөвшөөрөл: Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт” нэртэй 40.64 га талбай бүхий ашигт малтмалын MV-000436 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Гурван тамга” ХХК-д 30 жилийн хугацаатай олгосон байна.

Улмаар 2020 оны 05 дугаар сарын 27–ны өдөр АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 174 тоот тушаалаар “Ирмүүн босго” ХХК-иас 2020 оны 05 дугаар сарын 27–ны өдөр АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 174 тоот тушаалаар “Цариг шонхор” ХХК-нд шилжүүлсэн байна. 2022 оны 11 дугаар сарын 25–ны өдөр АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 95 тоот тушаалаар “Эм эс бэл майнинг” ХХК-нд шилжүүлсэн байна.

Ашиглалтын системийн сонголт: Ордуг ил аргаар ашиглана.

Ордын нөөцийн тооцоо: Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл ордын нөөцийг боломжтой С зэрэглэлээр 95.25 мян.м³ элсний нөөц, 6.99 кг буюу химийн цэврээр 5.86 кг, Өртөнтийн алтны шороон ордын нөөцийг бодитой В зэрэглэлээр 23.68 мян.м³ элсний нөөц, 7.1 кг буюу химийн цэврээр 5.95 кг, боломжтой С зэрэглэлээр 3.92 мян.м³ элсний нөөц, 1.07 кг буюу химийн цэврээр 0.89 кг, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлийн 122.8 мян.м³ элсний нөөц, 15.16 кг буюу химийн цэврээр 12.70 кг алтны нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Үйлдвэрлэлийн нөөц: Ордын нийт магадласан (В') үйлдвэрлэлийн нөөц нь 132.87 мян.м³ элс буюу хими цэврээр 12.37 кг алт болж байна. /Шлихээр 14.76 кг/.

2026 оны уулын ажлын төлөвлөлт: 2026 онд 18.61 мян.м³ элс олборлож 56.84 мян.м³ хөрс хуулна. Хими цэврээр 3.4 кг алт авна.

Уурхайн ажлын горим: Уурхайн олборлолт хөрс хуулалтын үйл ажиллагаа нь тухайн жилийн II-р улирлаас III-р улиралын хооронд дулааны улиралд явагдах бөгөөд техникийн даалгаврын дагуу 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Угаан баяжуулах хэсэг нь 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Ашиглалтын технологи. Шимт хөрсийг САТ D-6 маркийн бульдозероор түрж шимт хөрсний овоолгод овоолно. Шимт хөрсний овоолгыг 350 градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна. Шимт хөрсийг уурхайн талбайгаас 0.3 метр зузаантайгаар шимт хөрс хуулж овоолно.

Уурхайн ашиглалтын нэг жилийн хугацаанд олборлолтонд Hyundai 520 маркийн 3.2 м³ утгуурын багтаамжтай 1 ширхэг экскаватор ажиллах бөгөөд техникийн бүтээл ордын элсийг (сийрэгжилт тооцсон) олборлоход хүчин чадал, нөөцийн хувьд бүрэн хүрэлцээтэй байна. Экскаватор хөрс болон элсэнд 1 явалтаар ажиллахаар УАТ-нд тооцсон.

Элс тээвэрлэлтэнд 18 м³-ийн тэвшний багтаамж бүхий HOWO ZZ3257M3241 загварын автосамосвал ажиллуулах ба тээвэрлэлтийн зай дунджаар 0.262 км байх юм. Тоног төхөөрөмжийн бүтээл болон ажлын хэмжээнээс хамааран уурхайн элс тээвэрт 1 автосамосвал ажиллах тооцоо гарсан.

Автосамосвалын тээвэрлэж ирсэн элсийг уурхайн угаах төхөөрөмжөөр баяжуулж хаягдал болон эфель гаалийг уурхайн ухагдсан хоосон орон зайд нөхөн дүүргэлт хийнэ.

Энэ нь олборлолтын явцад элс олборлолтын автосамосвалын мөчлөгийн хугацааг уртасгах эфель гаалийг ухаж ачих тоног төхөөрөмж шаардагдах боловч уурхайн үйл

ажиллагаанаас үүдэлтэйгээр эвдрэлд орох газрын хэмжээг бага байлгах, мөн түүнчлэн нөхөн сэргээлтийн зардлыг бууруулах олборлолтын өртөгт шингээх, газрын хэвлийд учруулах хохирлын хэмжээг багасгах зэрэг давуу талуудтай юм.

Тооцоогоор элс тээвэрт 1 ширхэг автосамосвал жил бүрийн уулын ажлыг бүрэн хангахуйц бүтээлтэй байна.

Ил уурхайгаас хуулах шимт хөрсийг уурхайн 1 талд шимт хөрсний овоолгод хураана. Хөрсийг гадаад, дотоод овоолгод, эфель, гаалийг уурхайн ашиглагдсан орон зайд дотоод овоолгод овоолно.

Баяжуулалтын технологи: Олборлолтын үеийн хаягдал бохирдлыг тооцсоноор нийт 2026 онд 18.61 мян.м³ буюу цагт 72.05 м³ элс угаан баяжуулна. Угаан баяжуулах хэсэг нь өдөрт 2 ээлжээр, нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Хүний нөөц, ажиллах хүч: Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордын уурхайд үндсэн 37 хүн ажиллах ба сарын дундаж цалин 1.8 сая төгрөг байна.

Эдийн засгийн үнэлгээ: 2026 онд ордод нэмэлт хөрөнгө оруулалт хийгдэхгүй байна. Үндсэн хөрөнгийн ЭХШ 2026 онд дунджаар 141.9 сая төгрөгийн хуримтлал бий болгож байна. Уурхайд нийт 37 хүн ажиллах ба 1 хүн сард дунджаар 1.8 сая төгрөгний цалин авна. 2026 онд 185 сая төгрөгний цалингийн зардал гаргана.

Ашиглалтын зардал нь хөрс болон элсний экскавацийн зардал, тээвэр, овоолгын зардал, баяжуулалтын зардал, уурхайн захиргаа, аж ахуйн зардал, уурхайн туслах ажлын зардал болон бусад зардлаас бүрдэх ба эдгээр зардлуудад тоног төхөөрөмжийн шатах тослох материалын зардал, дугуйн зардал, сэлбэг хэрэгслийн зардал, операторын цалин хөлс, ЭМ, НД шимтгэл, кемпийн үйлчилгээний зардал болон түүний хөдөлмөр хамгаалал, эрүүл мэндийн зардлууд багтана. 2026 оны нийт ашиглалтын зардал 1040.0 сая төгрөг болж байна.

2026 онд улс, орон нутгийн төсөвт 154.67 сая.төг төгрөгийн орлого оруулахаар байна.

II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газарзүйн нөхцөл: Судалгааны талбай Монгол орны газарзүйн мужлалаар Евроазийн шилмүүст ой нуга, хээрийн ба хуурай хээрийн их муж багтана. Дорнод Азийн дэд тойрог Хэнтийн өмнөд бэсрэг ба нам уулын тойрогт хамаарна. Хангай ар говийн мужуудын тал хээрийн бүсэд хамаарагдана. Зүүн хойд хэсгээр нь далайн төвшингөөс дээш 2300-2400 метр хүртэл өндөр 15-18 км хүртэл урт Хараат-Ширээт нуруу үргэлжилнэ. Өртөнтийн амны газрын дундаж өндөр 1920-2100 м (д.т.д) орчим, хамгийн нам цэг Өвтийн гол 1950 м д.т.д Уулсын орой нь тэгшивтэр хад, асга ихтэй, ар хажуугаараа хар модон ой голлон зонхилно. Уулсын өвөр хажуу нь модгүй, алаг өвс-үетэнт ургамал зонхилсон уулын хээр, уулын нугат-хээртэй. Жижиг голын дагуу алаг өвс-улалжит нугын ургамалшилтай. Уулзүйн тогтоцоор Хангайн уулархаг өндөрлөгийн зүүн хэсэгт багтана.

Уур амьсгал: Эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөлөөс шалтгаалан өвөл нь харьцангуй хүйтэн, зундаа халуун байдаг. Сарын дундаж температур 1 дүгээр сард -27.40°C ба 7 дугаар сард 17.10°C байдаг. Хамгийн өндөр температур 7 дугаар сард 390°C хүрч, 1 дүгээр сард -400°C хүрч хүйтэрдэг байна.

Усан орчин: Төслийн талбай нь Онги-Таац голын сав газарт харъяалагдана. Умард мөсөн далайн ай сав, Төв азийн гадагшаа урсгалгүй ай сав, Төв азийн гадагшаа урсгалгүй ай сав голуудын эх авдаг бөгөөд Онгийн голын эхний салбар цутгалуудын жижиг усан хагалбаруудаас бэсрэг уулсын гадаргууд шилжих зааг хэсэгт оршино.

Хөрс: Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн дэд муж Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс, Туул-Дашинчилэнгийн тойрогт хамаарагдана. (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009). Уулын хар хүрэн хөрс нь далайн түвшнээс дээш 1245-1254 метрийн өндөрт байрласан нам уулс, ухаа толгодыг хамарч тогтворжсон байна.

Өвтийн голын хойд талд 2302-2392м-ийн өндөртэй уулсын хоорондох нарийн хөндийд хойноос урагш чиглэлтэй сунаж тогтсон байрлалтай байна. Энэ газар нь хөрс газарзүйн мужлалтаар уулын ойт хээр, хээр хосолосон Хангайн мужийн уулын тайгын ширэгт, уулын хар хүрэн хөрстэй Хангайн өндөр уулын тойрогт багтана.

Ургамал: Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын газар нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Евроазийн шилмүүст ой нуга, хээрийн ба хуурай хээрийн их муж багтана.

Дорнод Азийн дэд тойрог Хэнтийн өмнөд бэсрэг ба нам уулын тойрогт хамаарна. (Монгол Улсын үндэсний атлас, 2009). Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сум болон төслийн талбайн район нь Монгол орны байгалийн мужлалаар хээрийн бүсэд багтана. Төслийн талбайд үетэн-алаг өвст бэлчээрийн төрөл тархсан байна.

Амьтны аймаг: Төслийн талбайн район монгол орны Хөхтөн амьтдын тархацын газарзүйн мужийн 7-р муж буюу Хойд говийн тойрогт хамаарагдана. Амьтны аймгаас нийтлэг буюу зөвхөн тал хээрийн нөхцөлд дасан зохицсон амьтад тохиолдоно. Үүнд: туулай хэлбэртнээс бор туулай, огодой, мэрэгчдээс үлийн цагаан оготоно, махан идэштнээс саарал чоно, хярс, үнэг, шувуудаас шооронэвэрт болжмор, монгол болжмор, шилийн сар, хөхтөн амьтнаас цагаан зээр зэрэг элбэг таардаг. Энэхүү бүс нутагт тохиолдох 6 баг, 17 овог, 40 төрөлд хамаарах 54 зүйл хөхтөн амьтан байдаг.

Нийгэм, эдийн засаг: Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумыг 1931 онд, хуучнаар Түшээт хан аймгийн Ахай бээсийн хошуунд Үйзэн вангийн хошуунаас Мөнх булаг, Шадав булаг гэдэг 2 жижиг сумыг нэгтгэн байгуулсан. Эмгэд, Цахиурт, Цохиот, Баян-Улаан, Хад, Дэвшил гэсэн 6 багийн нийт 1105 өрхөд 3842 хүн амьдардаг.

III ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайд ачих, зөөж тээвэрлэх, боловсруулах тоног төхөөрөмж болон бусад машин механизмуудад урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, шингэн түлш, тос хүлээн авах, хадгалах, түгээх зориулалттайгаар засварын жижиг хэсэг ажиллана. Эдгээр үйл ажиллагааны явцад алтны үүсмэл шороон ордын газрын гадарга, хэвлий нь техникийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөлд өртөхөөр байна,

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Агаарын бохирдол /уурхайн малталт, овоолгууд, тээвэрлэлтийн зам болон хөрс хуулалт зэрэг технологи ажиллагаанаас тоос дэгдэнэ/,
- Тээврийн хэрэгслийн шаталтат хөдөлгүүрээс ялгарах утаа тортогоос үүсэх бохирдлын нөлөө,
- Түр суурьшлын бүсэд хог хаягдал, шатах тослох материалын үнэр хүрээлэн буй орчинд тархана,
- Үйлдвэрлэлийн дотоод тээврийн замын нөлөөгөөр хөрсний бүтэц алдагдсанаас нарийн ширхэгтэй тоос агаарт дэгдэж тэр хэмжээгээр орчны газрын хөрс, ургамлан нөмрөгийг доройтолд оруулах.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Төслөөс гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл байхгүй байна,
- Төслийн технологийн хэрэгцээнд хэрэглэх усыг газрын доорх усаас авч ашиглах учир гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсэх,
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал уурхайн орчинд тархаснаас хөрсийг бохирдуулснаас гүний усыг бохирдуулах,
- Тунаах нуурын далангийн суурийн бат бөх байдал, далан сэтэрч болзошгүй.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийн доройтол эрчимжинэ,
- Уурхайн дотоод тээврээр хөрс, ургамал талхлагдана,
- Уурхайд олон салаа шороон зам үүссэнээс хөрсний элэгдэл эвдрэл үүсэх,
- Шатах тослох материалын ашиглалт, хадгалалтаас үүдэлтэй хөрсний бохирдол хязгаарлагдмал орчинд үүснэ,
- Түр суурьшлаас эх үүсвэртэй хог хаягдлаар хөрс бохирдох,
- Тунгаах нуурын шаланд тунасан лаг орчныг хөрсийг бохирдуулах.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:

- “Өртөнтийн урд дэнжийн хэсэг” -ын алтны шороон ордын үйл ажиллагаа явагдаад олон жил болж байгаа учир олон салаа зам гаргах, ус цуглуулах зорилгоор татсан шуудуу, газрын эвдрэлээс шалтгаалсан доройтол олборлох үйл ажиллагаа явагдсан хэсгээр байна. Цаашид ашиглалтын талбай нэмэгдэхийн хирээр ургамалд үзүүлэх сөрөг нөлөөний цар хүрээ тэлэх боловч нөлөөллийн эрчим өсөхгүй,
- Уулын ажлын үед тээвэрлэлт, түр зам ашиглалт, орчны газар ашиглалт, тоосжилтоос ургамлын ургах орчин доройтох.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагаа, машин техник, тоног төхөөрөмжийн дуу чимээ, хөдөлгөөнөөс амьтад дайжин амьдрах орчин өөрчлөгдөх,

- Уурхайн ухсан нүх суваг, шуудуу руу мал амьтан уурхайн талбай руу унаж, бэртэх аюултай.

Нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурьшил байхгүй,
- Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт түр ажлын байр бий болно,
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ,
- Улс орны төсөвт мөнгөн хуримтлал бий болгоно,

Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай.

IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаа эхлээгүй үед хийгдэж байгаа учраас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБҮ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БОМТ-ний бүтэц: БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
7. Дүгнэлт

V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар							
1	Хөрс хуулалт, барилгын чулуу олборлолт, тээвэрлэлт, хөрсний овоолгоноос тоосжилт үүсэж орчны агаар орчныг бохирдуулах	Тоос үүсгэх талбайг тогтмол услах	Тээврийн зам	-	Усны төлбөрт орсон	Тогтсон хугацаанд	-MNS 0017-2-3-16:1988. Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам. - MNS 3384-1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага. - MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
2	Хүнд машин механизмын нөлөөгөөр Nox, CO, Sox хийгээр агаар орчныг бохирдуулах	Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Хүнд машин, техникүүд		350,000	Тогтсон хугацаанд	
Гадаргын ба газрын доорхи усны нөөц							
1	Газрын доорх усны нөөцөд нөлөөлөх	Усны төлбөрийг тогтсон хугацаанд жил болгон төлж байх	-	-	Дотоод зардал	Жил бүр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль / Ерөнхий сайдын захирамжийг мөрдлөг болгох / Ус ашигласны төлбөр (2009 оны 351-р тогтоол)
2	Хөрсний ус санамсаргүйгээр бохирдох	Шатах тослох материал хөрсөнд алдагдахаас сэргийлж ШТМ-ын агуулах орчмыг хатуу хучилттай болгох, засварлах	ШТМ агуулах	төг	500,000	Эвдэрсэн тохиолдолд засварлана	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч							

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ӨРТӨНТИЙН УРД ДЭНЖИЙН ХЭСЭГ”-ИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ БОЛОН ШОРООН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	6	7	8
1	Хөрс доройтох, цөлжих Хөрсний бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөх	Ашиглаж дууссан талбайд нөхөн сэргээлт хийх	Уурхайд		-	-	-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль -MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойолох арга, -MNS 4006:1987 Хөрс. MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга -MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
2	Зам дагуу хөрс эвдэрч, тоос тархах	Зам арчилгааны зардал, эвдэрсэн тохиолдолд засах	Зам		Дотоод төлөвлөлтөөр	Эвдэрсэн үед	
3	Хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтгэх	Зөвхөн маршрутын замаар машин техникүүдийг зорчуулах,	Зам, талбайд		-	Тогтмол	
4	Хөрс хуулалт, хөрсний овоолгоос газрын гадаргын хэлбэр төрх өөрчлөгдөх, эвдрэх	Ил уурхайн талбайн хэмжээнээс хэтэрч ажиллахгүй байх, хянах	Ил уурхай		-	-	
Ургамлан нөмрөг							
1	Ургамлын биомассд нөлөөлөх	Тоос үүсэх талбайг услах, олон салаа зам гаргахгүй гаргасан замаараа зорчих	Уурхайд		Усалгааны зардалд орсон	Тогтсон хугацаанд	
Нийт				төг	850,000.0		

V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нь “Өртөнтийн урд дэнжийн хэсэг”-ийн алтны үүсмэл шороон ордын 2026 онд өөрийн ашигласан талбайд дотоод овоолгоор нөхөн дүүргэж техникийн нөхөн сэргээлтийн хийхээр төлөвлөсөн бөгөөд тус ажлыг “үйл ажиллагааны зардал”-аар хийж гүйцэтгэнэ. Ордыг бүрэн ашиглаж дууссаны дараа биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийх тул 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тооцоогүй болно.

V.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө							
№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	6	7	8
1.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх ёстой байдаг.	Орон нутгийн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч, саналын дагуу ажлыг хийж гүйцэтгэнэ.	Өвөрхангай аймаг, Зүүнбаян-Улаан сум		8,000,000.0	2026 онд	МУ-ын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журам, стандартын дагуу
Нийт					8,000,000.0		

V.4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигт зааснаар тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд Төсөл хэрэгжүүлэгч нь Зүүнбаян-Улаан сумын ЗД-тай зөвшилцөж сумын төвд 200ш модын тарьж ургуулахаар төлөвлөлөө. Төслийн БОННУ-нд тусгасны дагуу сонгогдсон газарт бургас, шар хуайс, үхрийн нүд зэргийг тарьж ургуулахаар тусгасан ба 1 наст суулгацаар тарина, нийт суулгацын 80% нь ургана гэж тооцов. Зардалд суулгацын үнэ, тээврийн зардал, тарих зардал, модны усалгаа, тордлогооны зардлыг тооцсон тооцсон дүнгээр нийт **3,000,000** төгрөг тусгав.

V.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Өртөнтний урд дэнжийн хэсэг”-ийн алтны үүсмэл болон шороон ордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй.

V.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй.

“Эм эс бэл майнинг” ХХК-ийн биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

V.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	5	6	7
1.	-Гэнэтийн осол аваар гарах, -Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, -Галын гэнэтийн аюул үүсэх	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянаж ажиллах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Үйл ажиллагааны зардлаар	Тогтмол	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхой-лолт, ерөнхий ангилал -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, -MNS 5390:2004, “ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
2		Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчдад	200,000	Жилд 1 удаа	
3		Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайн кемп орчимд	300,000	Уурхайн үйл ажиллагааны явцад	
4		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж шаардлагатай газруудад байрлуулах	Уурхайн кемп орчимд	100,000	Уурхайн үйл ажиллагааны явцад	
5		Гамшгаас хамгаалах эрсдэлийн төлөвлөгөөний тайланг боловсруулан аймгийн ОБГ-р батлуулж мөрдөж ажиллах	Уурхайн удирдлага	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	
6		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангах (өлмийний хамгаалалттай түрийтэй гутал, хамгаалалтын нүдний шил, дуулга, тоосны маск, ажлын бээлий гэх мэт)	Уурхайн ажилчид	ХАБЭА-н зардалд тусгагдсан	Жил бүр	
7		Далан, хаягдлын санг үер усны үед хальж урсахаас урьдчилан сэргийлэх, байнга тогтворжуулж эвдрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, хяналт мониторинг хийх	Уурхайн удирдлага	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	
Нийт				600,000		

V.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Эдгээрт:

- Уурхайн хог хаягдлыг багасгах, хянах дотоод журам боловсруулж, хогийг ангилан ялгаж дахин ашиглах хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
- Дахин ашиглагдах боломжтой хог хаягдлын ангилан ялгалтын хувь хэмжээг нэмэгдүүлж, уурхайн үйл ажиллагааны улмаас бий болсон дахин ашиглагдах хог хаягдлыг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх үйл ажиллагааг бий болгоно.

Хүснэгт 6.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	7	8	9
1.	Хог хаягдлаас орчны бохирдол үүсэх	Хог тээвэрлэх компанитай байгуулсан гэрээний дагуу хогийг цаг хугацаанд нь тээвэрлүүлж байх	Хогийн цэг	450,000.0	Жил бүр	-Хог хаягдлын тухай хууль
Нийт				450,000.0		

V.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Уурхайн эдэлбэр газрын агаарын чанарт уурхай, баяжуулах хэсэг, машин техник, салхи болон машин тэрэгний хөдөлгөөнөөс үүссэн шороо тоос нөлөөлдөг. Компаний зүгээс төсөл хэрэгжих газрын агаарын чанарт уурхайн үйл ажиллагаанаас нөлөөлж буй нөлөөллийг ашиглалтын явцад тоосонцор хэмжигч ашиглан хяналт шинжилгээ хийлгэх, зам болон ажлын талбайнуудад тоосны хэмжээг багасгахын тулд байнга усалж байна. Эргэлтийн усан сангийн усны түвшинг тодорхой хугацаанд хэмжих бөгөөд нэвчилтийн алдагдлыг тодорхойлох арга хэмжээг шаардлагатай тохиолдолд авч байна.

Хүснэгт 7.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаар						
1	Агаарын тоосны (TSP,PM ₁₀ ,PM _{2.5}) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Бутлуур, дотоод тээвэрлэлтийн замаас, ил уурхай	Жилд 1 удаа	75,000	Цаг уур орчны шинжилгээний газрын байгаль орчны хэмжилзүйн төв лаборатори	- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль -MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 0017-2-3-16:1988. Агаар мандал. Хот суурингийн агаарын бохирдлын шинжилгээ - MNS 5061:2001. Нүүрсхүчлийн хий.CO ₂ тодорхойлох эзлэхүүний арга
2	Дуу чимээ, агаарын чийгшил, хөрсний температур хэмжих	Бутлуур, ил уурхай, уурхайн кемп	Жилд 1 удаа		/Multi-Function environment meter багажаар хэмжих/	
Хөрс						
3	Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	Уурхайн карьерийн гадна талаас зонхилох салхины чиглэлийн дагуу	Жилд 2 удаа	40,000	ШҮА, Газарзүй-Геозкологийн хүрээлэн, хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. -MNS 3985: 87. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл -MNS 3310:91. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
4	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	Шатах тослох материалын агуулах, бохирдсон байж болох цэгүүдэс дээж авах	Жилд 1 удаа	45,000		
Ус						

5	Усны химийн шинжилгээ (pH, EC, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Ахуйн хэрэглээний уснаас	Жилд 2 удаа	92,000	ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, усны шинжилгээний лаборатори	- MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ - MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага - MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга. - MNS5667-2:2001 Усны дээж. Дээж авах. 2-р хэсэг. Дээж авах аргачлалын заавар - MNS4867:1999 Усны чанар – Дээжлэх – Хэсэг 3. Авсан дээжийг зөөвөрлөх хадгалах арга
Нийт зардал				252,000		

V.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

“Эм Эс бэл майнинг” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Баримтлах стандарт ба аргачлал, тайлбар
	1	2	3	4	5	6
1.	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Ажилчид	Үйл ажиллагааны зардлаар	Жилд 1 удаа	“Эм Эс бэл майнинг” ХХК	-MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага -MNS 12.4. 005 - 1985 Хөдөлмөр хамгаалал. –жил бүр Шуугианаас -хамгаалах хэрэгсэл ба аргууд
2.	Газрын төлөв байдал чанарын захиалат хянан батлагаа мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	Гэрээний дагуу	5 жил тутам	“Эм Эс бэл майнинг” ХХК	
3.	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Алтны шороон орд	4,000.000	2 жил тутам	“Эм Эс бэл майнинг” ХХК	
4	БОМТ-ний биелэлтийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь өгч байх	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардалд орох	Жил бүр	“Эм Эс бэл майнинг” ХХК	
5	Жил бүрийн БОМТ-г БОАЖЯ-аар хянуулан баталгаажуулах	Уурхайн удирдлага	Үйл ажиллагааны зардалд орох	Жил бүр	“Эм Эс бэл майнинг” ХХК	
Нийт			4,000,000.0			

V.11 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

"Эм эс бэл майнинг" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн нь төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 9. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлдөд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ, ОХШХ-ийн биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	6	7
1	Өвөрхангай аймаг, Зүүнбаян-Улаан сум	Уулзалт, санал асуулга, тайлан хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	11-р сард	Уурхайн удирдлага	Өвөрхангай аймаг, Зүүнбаян-Улаан сум
2	Өвөрхангай аймгийн БОГазар, БОУАӨЯ-д.	Тайлан хэлбэрээр, албан бичиг	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийн тайлан болон тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	1-р улирал,		БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийн тайлан болон тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Улирал тутам буюу 7, 11 сард	Уурхайн удирдлага	Засаг даргын тамгын газар

V.12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт 10. Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	850,000
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	8,000,000
3	Тэрбум мод тарих төлөвлөгөө	3,000,000
4	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	600,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	450,000.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	252,000.0
7	БОМТ-г хэрэгжүүлэх тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4,000,000.0
8	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
Нийт		17,152,000.0

“Эм Эс бэл майнинг” ХХК-ний “Өртөнтийн урд дэнж хэсэг”-ийн алтны үүсмэл болон шороон ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2026 онд нийт 17,152,000.0 төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

ДҮГНЭЛТ

“Эм Эс бэл майнинг” ХХК-ийн Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ашиглах төсөл нь өмнөх жилүүдэд бүрэн хүчин чадлаар ажиллаж чадаагүй, ордын нөөцийг бүрэн ашиглаж дуусаагүй байгаа тул 2026 онд уурхайн хаалт хийгдэхгүй. Иймд төслийн БОННУ-ний тайлангийн хаалтын өмнөх жилийн менежментийн төлөвлөгөөг урьтал болгон 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 17,152,000 төгрөг гарахаар тооцоолсноос 50% –ийг нь Байгаль орчин, нөхөн сэргээх санд байршуулах зайлшгүй шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

“Өртөнтийн урд дэнжийн хэсэг”-ийн алтны үүсмэл болон шороон ордын үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
6. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол-1, 2023 он
7. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ашиглах ТЭЗҮ 2022 он
8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014 он
9. <http://www.legalinfo.mn>